



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/660

Мөрөн сум

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5, 14 дүгээр зүйлийн 14.7, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, 94 дүгээр зүйлийн 94.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох (1) аж ахуйн нэгжийн нэр, талбайн хэмжээ, байршил, солбицол, тусгай зөвшөөрлийн хугацааг хавсралт ёсоор баталсугай.

2.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал), Бүрэнтогтох сумын Засаг дарга (А.Аззаяа) нарт тус тус даалгасугай.

3.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын талбайг аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгаж ажиллахыг аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т даалгасугай.


4. Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг аймаг орон нутгийн орлогод төвлөрүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа)-т үүрэг болгосугай.

5. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ





Аймгийн Засаг даргын 2023  
оны 12 дугаар сарын 20-ний өдрийн А/.....  
дугаар захирамжийн хавсралт

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН ТАЛБАЙ, СОЛБИЦОЛ, ХУГАЦАА

№	Аж ахуйн нэгжийн нэр	Сум, талбайн нэр	Талбайн хэмжээ га	Хугацаа		Солбицол	
				Эхлэх	Дуусах	Уртраг	Өргөрөг
1	Хүслэнт бүтээмж ХХК	Бүрэнтогтох сум Ханжаргала нтын.ам	26,5	2023 оны 12 сарын 20	2026 оны 12 сарын 20	100 04 21.46	49 40 54.25
						100 04 42.51	49 41 5.67
						100 04 2.62	49 41 11.37
						100 04 1.11	49 41 6.28
						100 04 2.27	49 41 0.06
						100 04 10.58	49 40 54.99
						100 04 21.46	49 40 54.25

ооо